



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

2020 оны 05 дугаар сарын 22  
№19 /1121/

**Монгол Улсын  
хууль**

**Гэрч, хохирогчийг хамгаалах  
тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай**

**Монгол Улсын Их  
Хурлын тогтоол**

**Монголбанкны Тэргүүн  
дэд ерөнхийлөгчийг томилох  
тухай**

**Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг**

**Шүүгчийн албан тушаалд  
шилжүүлэн томилох тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

198.	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	902
199.	Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	907
200.	Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай	907
201.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	908

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

202.	Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай.	Дугаар 36	908
203.	Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай	Дугаар 37	909
204.	Монголбанкны Дэд ерөнхийлөгчийг томилох тухай	Дугаар 38	909
205.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 48	910

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

206.	Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай	Дугаар 29	910
207.	Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай	Дугаар 30	911
208.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 32	911

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

209.	Аргачлал шинэчлэн батлах тухай	Дугаар 445	912
210.	Үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрмийг батлах тухай	Дугаар 458	925



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт, тайлбар нэмсүгэй:

#### **1/13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг:**

“13.2. Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах асуудлыг нарийвчлан зохицуулсан стандартыг холбогдох байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана.”

#### **2/15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалт:**

“15.2.4. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;”

#### **3/15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг:**

“15.4. Солигдсон баримт бичгийг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу хадгалж, хамгаалах бөгөөд баримт бичгийг солих нөхцөл байдал арилсан тохиолдолд тухайн этгээдийн хүсэлтийн дагуу солигдсон баримт бичгийг сэргээж, өөрчлөлт оруулах асуудлыг энэ хуулийн 21.5-д заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.”

#### **4/17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг:**

“17.4. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан агуулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээтэй хамт хэрэгжүүлж болно.”

#### **5/18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалт:**

“18.1.4. нийгмийн бусад туслалцаа.”

#### **6/18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэг, тайлбар:**

“18.5. Энэ хуулийн 18.1.4-т заасан туслалцаа үзүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.”

Тайлбар: Энэ хуульд заасан “нийгмийн бусад туслалцаа” гэж хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн амьдралын зайлшгүй хэрэгцээт хоол хүнс, хувцас, шаардлагатай бусад ахуйн хэрэгцээ болон насанд хүрээгүй гэрч, хохирогчийн суралцах хэрэгцээг хангахад чиглэсэн төрөөс үзүүлж байгаа тусламж үйлчилгээг ойлгоно.”

#### **7/20 дугаар зүйлийн 20.4, 20.5 дахь хэсэг:**

“20.4.хамгаалалтын арга хэмжээг цуцлах шийдвэр гаргахад энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан нөхцөлийг харгалзан үзнэ.

20.5.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн бичгээр гаргасан санал, шүүхийн шатанд прокурорын бичгээр гаргасан саналын дагуу хамгаалалтын арга хэмжээг авахад гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгчийн саналыг авсан байна.”

#### **8/21 дүгээр зүйлийн 21.8-21.10 дахь хэсэг:**

“21.8.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд энэ хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмыг баримтална.

21.9.Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.10.Энэ хуулийн 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.6, 7.1.7, 7.1.8, 7.1.9-д заасан хамгаалалтын арга хэмжээг авахдаа хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага нь хамгаалалтад авах гэрч, хохирогч, хамтран хэрэгжүүлэх байгууллагатай гэрээ байгуулах бөгөөд гэрээний загварыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хэлбэрээс хамаарч гэрээнд холбогдох эрх, үүрэг, хариуцлагыг тусгана.”

#### **9/23 дугаар зүйлийн 23.3.9 дэх заалт:**

“23.3.9.хамгаалалтад авсан гэрч, хохирогчийн талаар мэдээллийн сан үүсгэн хөтлөх;”

#### **10/25<sup>1</sup> дүгээр зүйл:**

##### **“25<sup>1</sup> дүгээр зүйл.Зөвлөл**

25<sup>1</sup>.1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх



чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана.

25<sup>1</sup>.2.Зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ахалж, бүрэлдэхүүнд нь санхүү, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий байгууллага, прокурор, шүүх, холбогдох бусад төрийн байгууллагын төлөөллөөс бүрдүүлж ажиллана.

25<sup>1</sup>.3.Энэ хуулийн 25<sup>1</sup>.2-т заасан зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

25<sup>1</sup>.4.Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

25<sup>1</sup>.5.Зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

25<sup>1</sup>.5.1.гэрч, хохирогчийг хамгаалах салбар дундын ажлыг уялдуулан зохицуулах;

25<sup>1</sup>.5.2.гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг шийдвэрлэх талаар санал боловсруулах, хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;

25<sup>1</sup>.5.3.холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллагад зөвлөмж өгөх;

25<sup>1</sup>.5.4.гэрч, хохирогчийг хамгаалах байгууллага, албадын алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

25<sup>1</sup>.5.5.иргэд, олон нийтэд хууль тогтоомжийг сурталчлах.”

**2 дугаар зүйл.**Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хянан шийдвэрлэх” гэсний дараа “ажиллагааны” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “хязгаарлах арга хэмжээнд” гэсний дараа “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “үл хөдлөх хөрөнгө,” гэсний дараа “хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл,” гэж, мөн хэсгийн “Шаардлагатай тохиолдолд” гэсний дараа “гэрч, хохирогчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэлийн талаарх мэдээлэлд өөрчлөлт оруулах,” гэж, мөн зүйлийн 11.2 дахь хэсгийн “гэрч, хохирогчийн” гэсний дараа “болон хамаарал бүхий этгээдийн” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “хууль ёсны асран хамгаалагч,” гэсний дараа “харгалзан дэмжигч,” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалтын “гэрч, хохирогч,” гэсний дараа “түүний хууль ёсны төлөөлөгч,” гэж, мөн

зүйлийн 21.5 дахь хэсгийн “батална.” гэсний дараа “Энэ хуулийн 10.2-т заасан бүсэд биечилсэн хамгаалалтыг хэрэгжүүлэх журмыг батлахдаа холбогдох байгууллагын саналыг харгалзана.” гэж, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “байгууллагууд нь” гэсний дараа “тухайн байгууллагын даргын дэргэд” гэж, мөн зүйлийн 23.3.6 дахь заалтын “өөрчлөх” гэсний дараа “, цуцлах” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “гомдлоо” гэсний дараа “дээд шатны прокурор болон харьяалах” гэж, мөн зүйлийн 24.2 дахь хэсгийн “Шүүх” гэсний дараа “болон прокурор” гэж, 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн “боловсруулж,” гэсний дараа “баталж” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг:**

“8.1.Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд халдахаар заналхийлбэл тухайн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар шүүгч, прокурор, мөрдөгч бичгээр урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.”

**2/11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг:**

“11.3.Гэрч, хохирогчийн нууцалбал зохих мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд танилцуулж болно.”

**3/20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг:**

“20.1.Хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх үндэслэл нь гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлт, мөрдөгч, прокурорын бичгээр гаргасан санал байна.”

**4/20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт:**

“20.2.1.хамгаалалтад байгаа гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлт, мөрдөгч, прокурорын бичгээр гаргасан санал;”

**5/21 дүгээр зүйлийн 21.2.2, 21.2.3 дахь заалт:**

“21.2.2.энэ хуулийн 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.6, 17.1-д заасан хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлт, мөрдөгчийн бичгээр гаргасан саналыг үндэслэн прокурор, шүүхийн шатанд прокурорын бичгээр гаргасан саналыг үндэслэн шүүгч;



21.2.3.энэ хуулийн 7.1.7, 7.1.8, 16.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг гэрч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн бичгээр гаргасан хүсэлт, прокурорын бичгээр гаргасан саналыг үндэслэн шүүгч.”

**4 дүгээр зүйл.**Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн, 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсгийн “гэмт хэрэг” гэснийг “эрүүгийн хэрэг” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “7” гэснийг “6” гэж, мөн заалтын “эрүүл мэндийг” гэснийг “ эрүүл мэнд болон сэтгэл зүйг” гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “гэмт хэрэг хянан” гэснийг “эрүүгийн хэрэг хянан” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “халхавч” гэснийг “зохиомол” гэж, 15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалтын дугаарыг “15.2.5” гэж, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн “нэгж” гэснийг “алба” гэж, 20 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 20.2 дахь хэсгийн, 21 дүгээр зүйлийн гарчгийн “Аюулгүй байдлын хамгаалалтыг” гэснийг “Хамгаалалтын арга хэмжээ” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалтын “16.2-т” гэснийг “16.2, 17.1-д” гэж, мөн заалтын “мөрдөн байцаагч” гэснийг “мөрдөгч” гэж, мөн зүйлийн 21.3 дахь хэсгийн “Мөрдөх албаны” гэснийг “мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын” гэж, 22 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 22.1 дэх хэсгийн, 23 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 23.1 дэх хэсгийн “Аюулгүй байдлын хамгаалалтын” гэснийг “Хамгаалалтын” гэж, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “нэгжтэй” гэснийг “албатай” гэж, мөн зүйлийн 23.3.3 дахь заалтын “шийдвэрлэх” гэснийг “хэрэгжүүлэх” гэж, 23.3.5 дахь заалтын “бусад нийгмийн үйлчилгээ” гэснийг “нийгмийн бусад туслалцаа” гэж, 23.3.9 дэх заалтын дугаарыг “23.3.10” гэж, мөн зүйлийн 23.4 дэх хэсгийн “нэгжийн” гэснийг “албаны” гэж, 23.5 дахь хэсгийн “харьяалах асуудлын” гэснийг “эрх хэмжээний” гэж, 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн “эрх бүхий” гэснийг “ажиллагаа явуулах” гэж, мөн зүйлийн 25.5 дахь хэсгийн “захиргааны” гэснийг “төрийн” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “21<sup>3</sup> дугаар” гэснийг “10 дугаар” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “энэ” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтын, мөн зүйлийн 20.3 дахь хэсгийн, 20.3.2 дахь заалтын, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “аюулгүй байдлын” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “хамгаалалтад байгаа” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4.п дэх дэд заалтын “арга хэмжээг хэрэглэх журам,” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

### АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“18.4.12.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулж, агаарын чанарыг сайжруулах зорилгоор “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлшийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар  
сарын 07-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар  
хот

### Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Очирхүүгийн Эрдэмбилэгийг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар  
сарын 07-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар  
хот

### Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Ганбямбын Дөлгөөнийг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар  
сарын 07-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар  
хот

### Монголбанкны Дэд ерөнхийлөгчийг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Ганболдын Энхтайванг Монголбанкны Дэд ерөнхийлөгчөөр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тухайн асуудлаар хууль гаргах шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 03 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Магнайбаярын Мөнхдавааг Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Лхагвасүрэнгийн Өлзийжаргалыг Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Болдбаатарын Батсайханыг Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүхийн шүүгч Дашцэрэнгийн Ренченхоролыг Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус шилжүүлэн томилсугай.

2. Адил шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилсон тул шүүгч Магнайбаярын Мөнхдавааг Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Лхагвасүрэнгийн Өлзийжаргалыг Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Болдбаатарын Батсайханыг Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Дашцэрэнгийн Ренченхоролыг Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

### **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2020 оны 03 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар  
хот

#### **Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн “Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай” 213 дугаар зарлиг, 2016 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн “Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 134 дүгээр зарлигийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

### **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2020 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Дугаар 32

Улаанбаатар  
хот

#### **Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:



Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргасан шүүгч Сосорбарамын Энхжаргалыг Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2019 оны 12 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 445

Улаанбаатар  
хот

### **Аргачлал шинэчлэн батлах тухай**

Төсвийн тухай хуулийн 56.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Аргачлалыг баримтлан орон нутгийн төсвийн төслийг боловсруулж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, аймаг, нийслэлийн төсөвт шилжүүлэх санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тухай бүр тогтоож байхыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Орон нутгийн төсвийн аргачлал батлах тухай” Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 30 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**САНГИЙН САЙД**

**Ч.ХҮРЭЛБААТАР**

Засгийн газрын 2019 оны  
445 дугаар тогтоолын хавсралт

### **ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА ТООЦОХ АРГАЧЛАЛ**

#### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулан дээд шатны төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг тодорхойлох,

төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээнд төсвийн хуваарилалтын тэгш зарчим баримталдаг байх зорилгоор орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцоход энэхүү аргачлалыг мөрдөнө.

1.2. Энэ аргачлалд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “орон нутгийн төсвийн суурь зарлага” гэж Төсвийн тухай хуулийн 4.1.30-д заасныг;

1.2.2. “санхүүгийн дэмжлэг” гэж Төсвийн тухай хуулийн 4.1.21-д заасныг;

1.2.3. “орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал” гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар болон сумын баг, дүүргийн хороо түүнчлэн Засаг даргын шууд харьяанд байгаа орон нутгийн төсөвт байгууллагын үйл ажиллагааны урсгал болон хөрөнгийн зардлын нийлбэрийг;

1.2.4. “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны зардал” гэж Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгө, аймгийн байгаль орчны газар, сум дундын ойн ангийн үйл ажиллагааны урсгал болон хөрөнгийн зардлын нийлбэрийг;

1.2.5. “орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээний зардал” гэж холбогдох хуулийн дагуу иргэдэд олгох энэ аргачлалын хавсралтад заасан тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээний нормативт хэмжээг;

1.2.6. “норматив” гэж тухайн үйлчилгээ, арга хэмжээнд зарцуулах нөөцийг хуваарилах зорилгоор тооцсон зардлын нэгжийн дундаж хэмжээг;

1.2.7. “зардлын суурь түвшин” гэж тухайн төсөв боловсруулах жилийн өмнөх оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн бодит хэмжээг.

**Хоёр. Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх зардлын ангилал, тэдгээрийн орц**

2.1. Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг дараахь байдлаар ангилна:

2.1.1. үйл ажиллагааны урсгал зардал:



2.1.1.1. цалин хөлс, нийгмийн баталгааны зардал;  
2.1.1.2. байр ашиглалттай холбоотой зардал;  
2.1.1.3. төрийн албан хаагчийн үйл ажиллагааны урсгал зардал;

2.1.1.4. бусад урсгал зардал.

2.1.2. хөрөнгийн зардал.

2.2. Цалин хөлс, нийгмийн баталгааны зардал нь дараахь орцоос бүрдэнэ:

2.2.1. жишиг нормативаар тогтоосон орон тооны цалин, нэмэгдэл;

2.2.2. нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл;

2.2.3. нэг удаагийн тэтгэмж болон урамшуулал.

2.3. Байр ашиглалттай холбоотой зардал дараахь орцоос бүрдэнэ:

2.3.1. түлш, халаалтын зардал;

2.3.2. цахилгаан эрчим хүчний төлбөр;

2.3.3. цэвэр, бохир усны төлбөр;

2.3.4. байрны түрээсийн төлбөр.

2.4. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны урсгал зардал дараахь орцоос бүрдэнэ:

2.4.1. бичиг хэргийн зардал;

2.4.2. тээвэр, шатахууны зардал;

2.4.3. албан томилолтын зардал;

2.4.4. нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал;

2.4.5. бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлсийн зардал;

2.4.6. хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардал.

2.5. Бусад урсгал зардал дараахь орцоос бүрдэнэ:

2.5.1. бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр;

2.5.2. хичээл сургалтын зардал;

2.5.3. урсгал засварын зардал;

2.5.4. багаж, техник хэрэгслийн зардал;

2.5.5. шуудан холбоо, интернетийн зардал;

2.5.6. ном хэвлэлийн зардал;

2.5.7. хог хаягдал зайлуулах зардал;

2.5.8. Засаг даргын нөөц хөрөнгө.

### **Гурав. Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх зардал тооцох аргачлал**

3.1. Цалин хөлсний зардлыг тооцохдоо дараахь зүйлсийг харгалзана:

3.1.1. захиргааны ажил, үүрэг гүйцэтгэх албан хаагчийн орон тооны нормативыг эрх бүхий байгууллагаас баталсан жишиг хязгаар эсхүл орон нутгийн төрийн нийтийн албаны байгууллагын орон тоог тогтоосон эрх бүхий байгууллагаас хамгийн сүүлд гаргасан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа шийдвэрийг үндэслэнэ;

3.1.2. тогтоосон орон тооны хязгаарыг нэмэгдүүлэх саналыг тухайн жилийн төсвийн бодлогод баримталж байгаа чиглэлийг үндэслэнэ;

3.1.3. үйлчилгээний ажил, үүрэг гүйцэтгэх нэг үйлчлэгчид ногдох талбайн хэмжээг дараахь байдлаар тооцож үйлчилгээний ажилтны орон тоог тооцно:

3.1.3.1. техник, хэрэгсэл ихтэй өрөөнд 395 метр квадрат талбайд нэг орон тоо байхаар;

3.1.3.2. техник, хэрэгсэл багатай өрөөнд 460 метр квадрат талбайд нэг орон тоо байхаар;

3.1.3.3. заал, танхим, коридор, шатны хэсэгт 700 метр квадрат талбайд нэг орон тоо байхаар;

3.1.3.4. цэвэрлэх үйлчилгээг 16 суултуурт 1 орон тоо байхаар.

3.1.4. албан байгууллагын талбайн хэмжээ нормд хүрэхгүй бол 2 буюу түүнээс дээш байгууллагын дунд 1 үйлчилгээний орон тоо байхаар зохицуулах буюу хавсран ажиллуулахаар тооцно;

3.1.5. аймгийн төвд албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан бүрд 1 жолоочийн орон тоо байхаар, суманд 1 жолоочийн орон тоо байхаар тус тус тооцно;

3.1.6. орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой цалин хөлсний зардлыг энэ аргачлалын 3.1.1-3.1.5-д заасан орон тооны жишигт үндэслэн Засгийн газраас хамгийн сүүлд баталсан төрийн албан хаагчийн цалин, нэмэгдлийн жишгээр тооцож гаргана;

3.1.7. улирлын үр дүнгийн урамшууллыг Засгийн газрын тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журамд заасны дагуу тооцно;





3.1.8. төрийн албан хаагчид олгох тэтгэмж, тусламжийг холбогдох эрх зүйн актад заасны дагуу тооцно.

3.2. Цалингаас тооцох нэмэгдэл, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн бусад актад заасан хувь хэмжээгээр тооцно.

3.3. Орон нутгийн төрийн нийтийн албаны байгууллагын байрлаж байгаа байрны түлш, халаалтын зардал, цэвэр болон бохир ус, цахилгаан эрчим хүч, байрны түрээсийн төлбөр зэрэг байр ашиглалтын зардлыг тухайн барилга байгууламжийн эзлэхүүн, өмнөх жилийн зардлын суурь түвшинг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөгдөж байгаа үнэ тарифын өөрчлөлттэй харьцуулан тооцно.

3.4. Энэ аргачлалын 2.4-т заасан төрийн албан хаагчийн үйл ажиллагааны урсгал зардлыг дараахь аргачлалаар тооцно:

3.4.1. бичиг хэргийн зүйлсийн хэрэгцээг тооцохдоо нэг албан хаагчид ногдох бичгийн цаас, хэвлэгчийн хор, бусад хэрэгслийн жилийн хэрэглээг А4 бичгийн цаасны хэмжээгээр илэрхийлэх бөгөөд дараахь нормтой байна:

№	Байгууллага	Нэг боодол А4 бичгийн цаасанд шилжүүлсэн норм, жилээр		
		ТЗ-У	ТЗ-Г	ТҮ
1.	Аймгийн Засаг даргын Тамгын газар	12	24	48
2.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	12	12	36
3.	Сумын Засаг даргын Тамгын газар	36	48	120
4.	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	36	48	0
5.	Бусад нийтлэг байгууллага	24	36	72

Тайлбар: Хүснэгтийн “ТЗ-У” ангилалд Төрийн захиргааны 9-14 дүгээр шатлал болон Улс төр, Төрийн тусгай албан хаагчдыг, “ТЗ-Г” ангилалд Төрийн захиргааны 1-8 дугаар шатлалын албан хаагчдыг, “ТҮ” ангилалд Төрийн үйлчилгээний 4-12 дугаар зэрэглэлийн албан хаагчдыг хамруулна. Харин Төрийн үйлчилгээ 1-3 дугаар зэрэглэлд багтах албан хаагчдад бичиг, хэргийн зардлын норм тооцохгүй. “Бусад нийтлэг байгууллага” гэдэгт орон нутгийн төсвийн бусад байгууллага хамаарах бөгөөд үүнд нийслэл, дүүргийн төрийн байгууллагууд мөн хамаарна.

3.4.2. бичиг хэргийн жилийн зардлыг тооцохдоо дараахь томъёог ашиглана:

$$TC_{sta} = [n \cdot TЗУ + n \cdot TЗГ + n \cdot TҮ] \cdot [P_{t-1} \cdot (1 + \pi_t)]$$

Энд,

$TC_{sta}$  - Бичиг хэргийн зардлын нийт хэмжээ

TЗУ, TЗГ, TҮ – Төрийн албан хаагчийн ангилал

n- төрийн албаны тухайн ангилалд хамаарах албан хаагчийн тоо

P- өмнөх жилээр тооцсон нэг боодол А4 цаасны зах зээлийн дундаж үнэ

Үнэ

$\pi_t$  - тухайн жилийн тооцсон инфляц

3.4.3. бичиг хэргийн бусад хэрэгсэл гэдэгт принтерийн хорны цэнэглэгч, архив, бичиг хэргийн ажилтанд шаардагдах зүйлс (албан бланк, албан томилолтын хуудас, бүртгэлийн дэвтэр), нягтлан бодогч болон няравт шаардагдах зүйлс (шаардах хуудас, бэлэн мөнгөний баримт, бүртгэлийн болон тооцооны дэвтэр)-ийг оруулан тооцно.

3.4.4. тээвэр шатахууны зардлын хэмжээг дараахь томъёогоор тооцно:

$$TFC = \sum_{i=1}^n (A_i \times E_i \times 12 \times C_i / 100 \times P_{i,t-1} (1 + \pi_t) + S_i) (D_j \times Z \times 0,5 + B I_j \times 0,5)$$

Энд,

$A_i$  - Өдөрт явах километрийн норм

$E_i$  - Сард явах ажлын хоног

$C_i$  - 100 километр зарцуулах шатахууны норм

$P_{i,t-1} - (t - 1)$  үеийн шатахууны үнэ

$S_i$  - Автомашины тослох материалын зардал

$D_j$  - Сумаас (аймгаас) аймгийн төв (нийслэл) хүртэлх зайн индекс

$Z$  - Аймгийн нутаг дэвсгэрийн шатахууны үнээс хамаарсан бүсийн нэмэгдлийн индекс

$B I_j$  - Замын бартаанаас хамаарсан индекс



3.4.5. Тээвэр шатахууны зардлын чиглүүлэгчийг дараахь байдлаар тогтооно:

3.4.5.1. өдөрт явах километрийн норм нь албан тушаалын автомашинд 70 км, албан ажлын автомашинд 50 км, дуудлагын автомашинд 40 км байна;

3.4.5.2. автомашины сард явах ажлын хоног нь албан тушаалын автомашинд сарын бүх өдрүүд, албан ажлын автомашинд сарын ажлын өдрүүд байна;

3.4.5.3. 100 километрт зарцуулах шатахууны нормыг Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1-7 дугаар хавсралтад заасан нормын дагуу тооцно;

3.4.5.4. автомашины тослох материалыг жилд нэг удаа тооцох ба тухайн үеийн 1 литр тослох материалын зах зээлийн үнийг автомашины маркаас хамааруулж ялгаатай тогтооно;

3.4.5.5. тухайн үеийн шатахууны зах зээлийн дундаж үнийг төсвийн санал боловсруулах үеийн шатахууны хэрэглээний үнийн харгалзах бүлгийн индексийн цэвэр өсөлтөөр өсгөж тооцно.

3.4.6. дотоод албан томилолтын жилийн дундаж хүн өдөр нь дараахь нормтой байна:

№	Байгууллага	Томилолтоор ажиллах байршил	Жилд томилолтоор ажиллах хүн/өдөр			
			ТЗ-У	ТЗ-Г	ТҮ	ТҮ-жолооч
1.	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Улаанбаатар	12.8	9.0	7.3	60.0
		Сум	34.1	18.4		19.5
2.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Улаанбаатар	13.0	12.9	4.9	50.4
		Аймаг	8.4	6.1	-	28.5
		Сум	17.6	12.0	-	50.0
3.	Сумын Засаг даргын Тамгын газар	Улаанбаатар	5.4	5.2	8.1	21.1
		Аймаг	2.7	2.4		4.7
4.	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Улаанбаатар	4.7	3.7	-	-
		Аймаг	3.0	3.0	-	-

5.	Бусад нийтлэг байгууллага	Улаанбаатар	9.9	6.6	6.9	51.7
		Аймаг	7.0	3.8	-	18.2
		Сум	15.4	22.0	-	22.2

Тайлбар: Хүснэгтийн “ТЗ-У” ангилалд Төрийн захиргааны 9-14 дүгээр шатлал болон Улс төр, Төрийн тусгай албан хаагчдыг, “ТЗ-Г” ангилалд Төрийн захиргааны 1-8 дугаар шатлалын албан хаагчдыг, “ТҮ” ангилалд Төрийн үйлчилгээний 4-12 дугаар зэрэглэлийн албан хаагчдыг хамруулна.

3.4.7. дотоод албан томилолтын жилийн зардлыг дараахь томъёогоор тооцно:

$$TC_{tr} = (P_d * TЗУ + P_d * TЗГ) * N1 + (P_d * ТҮ + P_d * ТҮЖ) * N2$$

Энд,

$TC_{tr}$  - жилийн нийт дотоод албан томилолтын зардал

$P_d$  - ТЗУ, ТЗГ, ТҮ, ТҮЖ ангилалд харгалзах хүн өдрийн норм

$N2$  - Сангийн сайдын тушаалаар баталсан дотоод албан томилолтын тариф

3.5. Энэ аргачлалын 2.4.4-2.4.6-д заасан зардлын хэмжээг өмнөх жилийн зардлын суурь түвшинг харгалзан бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтөөр индексжүүлнэ.

3.6. Энэ аргачлалын 2.5-д заасан бусад урсгал зардлын нийт хэмжээг тооцохдоо зардлын суурь түвшинтэй нь харьцуулах бөгөөд дараахь зүйлсийг харгалзана:

3.6.1. үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөд хийх урсгал засварын зардлыг үлдэгдэл өртгөөс дараахь хувь хэмжээгээр тооцож төлөвлөнө:

А. Барилга байгууламж

Ашиглалтын хугацаанаас хамаарч урсгал засварын зардал тооцох хувь хэмжээ					
5 жил хүртэл	5-10 жил	10-15 жил	15-20 жил	20-30 жил	30-40 жил
0.5 %	1%	3%	5%	7%	9%



**Б. Автомашин**

Ашиглалтын хугацаанаас хамаарч урсгал засварын зардал тооцох хувь хэмжээ								
1-3 жил			3-6 жил			6-10 жил		
Суудлын автомашин 2500 см <sup>3</sup> -ээс бага	Суудлын автомашин 2500 см <sup>3</sup> -ээс их	Технологийн автомашин	Суудлын автомашин 2500 см <sup>3</sup> -ээс бага	Суудлын автомашин 2500 см <sup>3</sup> -ээс их	Технологийн автомашин	Суудлын автомашин 2500 см <sup>3</sup> -ээс бага	Суудлын автомашин 2500 см <sup>3</sup> -ээс их	Технологийн автомашин
1%	3%	5%	2%	3%	6%	3%	4%	7%

3.6.2. эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтлэг үйлчилгээний 1 удаагийн үнэ тариф (хог хаягдал г.м.);

3.6.3. дээд шатны байгууллагаас тухайн төсвийн жилд хэрэгжүүлэхээр заасан нэг удаагийн арга хэмжээ;

3.6.4. Аймаг, сумын Засаг даргын нөөц хөрөнгийн хэмжээг тооцохдоо тухайн засаг захиргааны нэгжийн хүн амын тоог харгалзана.

3.7. Дээд шатны төсвийн захирагч нь хувьсах зардлыг тухайн орон нутгийн онцлогтой уялдуулан доод шатны төсөвт хуваарилна.

3.8. Хэрэв холбогдох салбарын хуулиар урсгал зардал тооцоход ашиглах тусгайлан тогтоосон хувь хэмжээ байгаа бол түүнийг баримтлан тооцно.

3.9. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индексийг Үндэсний статистикийн хорооноос аймаг тус бүрээр тооцон гаргасан мэдээллийг ашиглаж тооцно.

**Дөрөв. Хөрөнгийн зардал тооцох**

4.1. Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн зардлыг дараахь байдлаар хянаж суурь зарлагад тооцно:

4.1.1. өөрийн хэрэгцээнд албан конторын барилга худалдаж авах эсхүл шинээр барих бол өмнөх барилгын ашиглалтын хэрэгцээ хангахгүй болсныг нотолсон мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулсан байх;

4.1.2. шинээр барих барилгын экспертизээр баталгаажуулсан зураг төсөв, техникийн бусад зөвшөөрлийг авсан байх;

4.1.3. их засвар хийхээр бол холбогдох төсвийг зохих норм, норматив, дүрмийн дагуу бэлтгэсэн байх;

4.1.4. тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдаж авахаар бол өмнө нь ашиглаж байсан хөрөнгө нь зохих элэгдлийн нормд заасны дагуу өртгөө бүрэн нөхсөн эсхүл зохих журмын дагуу хэрэглээнээс актлагдсан бол орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэлээс хасагдсаныг нотолсон байх;

4.1.5. албан ажлын хэрэгцээнд уналгын автомашин өөрийн хөрөнгөөр худалдаж авахаар бол холбогдох үнийн саналын судалгааг бэлтгэсэн байх. Тухайн онд худалдан авах автомашин нь 0-3 жилийн өмнө үйлдвэрлэгдсэн, тухайн онд Монгол Улсад импортоор орж ирсэн байх;

4.1.6. шинэ хөрөнгө оруулалттай холбоотойгоор нэмэгдэх орон тоо, урсгал зардлын хэмжээг тооцсон байх.

#### **Тав. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал тооцох**

5.1. Аймаг, нийслэлийн байгаль хамгаалах газрын үйл ажиллагааны урсгал зардлыг дараахь байдлаар тооцно:

5.1.1. орон нутгийн байгаль хамгаалах ажилтны цалин хөлс, нийгмийн баталгаа, болон байр ашиглалттай холбоотой зардлыг энэ аргачлалын 3.1.6-3.1.8, 3.2, 3.3-т тус тус заасны дагуу;

5.1.2. төрийн албан хаагчийн үйл ажиллагааны зардал болон бусад урсгал зардлыг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан орон нутгийн иргэдийн төлөөллийн болон засаг захиргааны нэгжийн удирдлагын байгууллагын хэрэгжүүлбэл зохих чиг үүргийг суурь түвшний төсөвтэй нь харьцуулж, дараахь зүйлсийг харгалзан тогтооно:

5.1.2.1. байгалийн бүсчлэлд хамрагдсан сумд;

5.1.2.2. байгаль хамгаалагчийн хариуцан ажиллах талбайн норматив;

5.1.2.3. улсын тусгай хамгаалалтад ороогүй объектыг орон нутгийн хамгаалалтад авч хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоох эсэх;



5.1.2.4. хот, тосгон, бусад суурин болон амралт, сувиллын газар, гол, мөрний эх, нуур, рашаан, булаг, шанд, уст цэгийн орчныг хамгаалах, эрүүл ахуйн шаардлагыг хангах тусгай бүсийн заагийг тогтоох эсэх;

5.1.2.5. байгаль орчны байцаагчийг нормын хувцас, ялгах тэмдэг, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах шаардлагатай эсэх;

5.1.2.6. харьяалах нутаг дэвсгэрийн байгалийн тогтоц, хэв шинж;

5.1.2.7. уул уурхайн олборлолт хийсний улмаас байгаль орчны үнэлгээ хийж байгалийг нөхөн сэргээх шаардлага гарсан эсэх;

5.1.2.8. байгалийн нөөцийг нөхөн сэргээх шаардлагатай эсэх.

5.2. Засгийн газраас тогтоосон байршил бүхий сум дундын ойн ангийн үйл ажиллагааны хувьсах шинжтэй урсгал зардлыг дараахь байдлаар тооцно:

5.2.1. цалин хөлс, нийгмийн баталгаа, болон байр ашиглалттай холбоотой зардлыг энэ аргачлалын 3.1-3.3-т заасны дагуу;

5.2.2. орон тооны дээд хязгаарыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан орон тооны жишиг, хязгаарын дагуу;

5.2.3. төрийн албан хаагчийн үйл ажиллагааны зардал болон бусад урсгал зардлыг холбогдох эрх зүйн актаар баталгаажсан чиг үүрэг, арга хэмжээг суурь түвшний төсөвтэй харьцуулж хянан тогтоохдоо дараахь зүйлсийг харгалзана:

5.2.3.1. Засгийн газраас тогтоосон ойн ангийн хариуцах талбайн норматив;

5.2.3.2. харьяалах нутаг дэвсгэрийн байгалийн тогтоц, хэв шинж;

5.2.3.3. байгаль хамгаалагчийг нормын хувцас, ялгах тэмдэг, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах шаардлагатай эсэх;

5.2.3.4. байгалийн нөөцийг нөхөн сэргээх шаардлагатай эсэх;

5.2.3.5. ой цэвэрлэх, нөхөн сэргээх шаардлагатай эсэх.

5.3. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх зориулалтаар зарцуулах хөрөнгийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан орлогын төрөл, хувь хэмжээгээр тооцно.

### **Зургаа. Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал тооцох**

6.1. Орон нутгийн төсвөөс санхүүждэг төрөлжсөн асрамжийн төв, сум, дүүрэг, хороодын ахмадын төв, сум, хорооны нийгмийн ажилтны хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны урсгал зардлыг дараахь байдлаар тооцно:

6.1.1. байгууллагын цалин хөлс, нийгмийн баталгаа болон байр ашиглалттай холбоотой зардлыг энэ аргачлалын 3.1-3.2-т заасны дагуу;

6.1.2. сум, хорооны нийгмийн ажилтны орон тоог Засгийн газраас тогтоосон нийгмийн үйлчилгээний жишиг нормативт заасныг баримтлан;

6.1.3. бусад урсгал зардлыг Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, Төсвийн тухай хуульд орон нутгийн иргэдийн төлөөллийн болон засаг захиргааны нэгжийн удирдлагын байгууллагын хэрэгжүүлбэл зохих чиг үүргийг суурь түвшний төсөвтэй нь харьцуулж дараахь зүйлсийг харгалзан хянан тогтооно:

6.1.3.1. нийгмийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэний тоог ядуурлын түвшинтэй нь харьцуулан;

6.1.3.2. нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээний төрөлжилт, төвлөрөл (тодорхой бүс, орон нутагт нэг болон түүнээс дээш төрлийн хөнгөлөлт, үйлчилгээний хуваарилалт бусад бүс болон орон нутагтай харьцуулахад их байх гэх мэт);

6.1.3.3. төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр аймаг, нийслэлийн Ахмадын хороотой Засаг даргын байгуулсан гэрээнд заасан цалин хөлс, урамшуулал болон үр дүнгийн бусад үзүүлэлтүүд;

6.1.3.4. ахмадын төв, кабинет, сувиллын үйл ажиллагаа явуулж байгаа байр, конторын өмчлөлийн харьяалал;

6.1.3.5. хүчирхийлэлд өртсөн иргэд, хүнд нөхцөлд байгаа хүүхдийн тоо болон гал түймэр, байгалийн гамшгийн улмаас орон гэрээ алдсан иргэдэд нийгмийн үйлчилгээний төвөөр дамжуулж тусламж үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлага байгаа эсэх;

6.1.3.6. төрөлжсөн асрамжийн төв тухайн орон нутагт ажилладаг эсэх;

6.1.3.7. хоноглох байр ажиллуулдаг эсэх;

6.1.3.8. нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний зардлын хэмжээг энэхүү аргачлалын хавсралтад заасан жагсаалтад үндэслэх бөгөөд холбогдох хууль, эрх бүхий байгууллагаас хамгийн сүүлд тогтоосон тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээний нэр төрөл, хэмжээг баримтална.





**Долоо. Суурь зардлын тооцооллыг нэгтгэх,  
тохируулга хийх**

7.1. Орон нутгийн суурь зардлыг орон нутгийн засаг захиргааны нэгж бүрээр тооцож гаргасны дараа нийт зардлын дүнг нэгтгэж, шаардлагатай бол дараахь тохируулгын аль тохирохыг хийнэ:

7.1.1. цалин хөлсний нэмэгдлийг тухайн жилийн төсвийн бодлогод тусгагдсан хэмжээгээр тооцож индексжүүлэх;

7.1.2. орон тооны тохируулгыг тухайн жилийн төсвийн бодлого болон бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн хүрээнд үндэслэн нэмэгдүүлэх эсхүл бууруулах;

7.1.3. нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн жилийн нэгдсэн төсвийн бодлогод тусгасан шийдвэрийг үндэслэх.

Орон нутгийн суурь зарлага  
тооцох аргачлалын хавсралт

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГАД ТООЦОХ НИЙГМИЙН  
ХАЛАМЖ, АСРАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ**

№	Төрөл
1.	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж
1.1.	Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрхөд олгох
1.2.	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд олгох
1.3.	Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд олгох
1.4.	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эхэд олгох
1.5.	Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.2.4-т зааснаас бусад хоёр болон түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох
1.6.	Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхэдэд олгох
1.7.	Байнгын асаргаа шаардлагатай 16 болон түүнээс дээш насны иргэнд олгох
1.8.	Гурав болон түүнээс дээш тооны 14 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд олгох
1.9.	Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхэд олгох



2.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
2.1.	Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах
2.2.	Зөвлөгөө өгөх
2.3.	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах
2.4.	Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах
2.5.	Өдрийн үйлчилгээнд хамруулах
2.6.	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах
2.7.	Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх
2.8.	Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах
2.9.	Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах
2.10.	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах
3.	Бусад
3.1.	Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ
3.2.	Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал
3.3.	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 458

Улаанбаатар  
хот

### Үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрмийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Цахим хөгжлийн үндэсний хорооны бүрэлдэхүүн”-ийг “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоолын 27 дугаар хавсралт болгон 1 дүгээр хавсралт, “Цахим хөгжлийн үндэсний хорооны дүрэм”-ийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.



2. Төрийн байгууллагуудад ашиглаж байгаа програм хангамжийг нэгдсэн нэг цонхонд ханддаг байхаар нэгтгэн зохион байгуулах замаар төрөөс үзүүлэх цахим үйлчилгээг нийтэд хүртээмжтэй, аюулгүй, шуурхай хүргэх шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Цахим хөгжлийн үндэсний хороо (Л.Оюун-Эрдэнэ)-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

Засгийн газрын 2019 оны 458 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

Засгийн газрын 2017 оны 27  
дугаар тогтоолын 27 дугаар хавсралт

**ЦАХИМ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Гишүүд: -Монголбанкны Ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр);

-Нийслэлийн Засаг дарга;

-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Тагнуулын ерөнхий газрын дарга;

-Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга;

-Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга;

-Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга;

-Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбооны ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр).

Нарийн бичгийн дарга

-Цахим хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга.

Засгийн газрын 2019 оны 458 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## **ЦАХИМ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү дүрэм нь цахим засгийн төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохицуулан зохион байгуулах үүрэг бүхий Цахим хөгжлийн үндэсний хороо (цаашид “Үндэсний хороо” гэх)-ны чиг үүрэг, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.



1.2. Үндэсний хороо нь үйл ажиллагаандаа харилцаа холбооны тухай хууль тогтоомж, Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого болон тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Үндэсний хороо нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэгтэй байна.

### **Хоёр. Үндэсний хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт**

2.1. Үндэсний хороо нь төр, олон нийтийн оролцоог хангасан төлөөллөөс бүрдсэн үндэсний хэмжээний орон тооны бус байгууллага мөн.

2.2. Шаардлагатай бол Үндэсний хороо төрийн үйлчилгээг цахимжуулж, иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэх тодорхой асуудлаар ажлын хэсэг, шинжээчдийн бүлэг байгуулан ажиллуулж болно.

2.3. Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

2.4. Үндэсний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

2.5. Үндэсний хорооны ээлжит хуралдааныг улирал тутам хийнэ. Шаардлагатай тохиолдолд Үндэсний хорооны даргын санаачилгаар, эсхүл Үндэсний хорооны гишүүдийн олонхийн саналаар ээлжит бус хуралдааныг хуралдуулж болно.

Хуралдаанд шаардлагатай тохиолдолд холбогдох төрийн байгууллагын төлөөлөл, эрдэмтэн, судлаач, хувийн хэвшлийн төлөөллийг тухайн байгууллагын удирдлагатай тохиролцсоны үндсэн дээр оролцуулна.

2.6. Үндэсний хорооны нийт гишүүдийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.7. Үндэсний хорооны даргын эзгүйд түүний үүргийг даргын эрх олгосноор хорооны аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

2.8. Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.



2.9. Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргаж Хорооны дарга гарын үсэг зурна. Үндэсний хороо шаардлагатай гэж үзсэн асуудлаар зөвлөмж, албан даалгавар гаргаж болох бөгөөд түүнд Үндэсний хорооны дарга гарын үсэг зурна.

2.10. Үндэсний хорооны хуралдааныг тэмдэглэл хөтөлж баталгаажуулах бөгөөд түүнд Үндэсний хорооны дарга, ажлын албаны дарга гарын үсэг зурна.

2.11. Үндэсний хорооны хуралдааны дэгийг Үндэсний хороо батална.

### **Гурав. Үндэсний хорооны чиг үүрэг**

3.1. Үндэсний хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого болон төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, Үндэсний хорооны шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах замаар цахим засгийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

3.1.2. цахим засаглалыг хөгжүүлэхтэй холбоотой асуудлаар хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр болон олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнтэй танилцах, зөвлөгөө өгөх;

3.1.3. цахим засаглалыг хөгжүүлэх талаарх үндэсний бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох, улс, орон нутгийн төсөвт тусгуулах талаар санал гаргах;

3.1.3. төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим засгийг хөгжүүлэх үйл ажиллагаанд гадаад, дотоодын хандивлагчдын тусламж, дэмжлэгийг авах;

3.1.4. цахим засгийг хөгжүүлэх үйл ажиллагаанд олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог хангах;

3.1.5. төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дүнгийн тухай мэдээлэх;



3.1.6. цахим засгийг хөгжүүлэх асуудлаар санал боловсруулж, Засгийн газарт танилцуулах.

**Дөрөв. Үндэсний хорооны дарга,  
гишүүний бүрэн эрх**

4.1. Үндэсний хорооны дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. Үндэсний хорооны ажлыг удирдлагаар хангаж, хорооны шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

4.1.2. Үндэсний хорооны ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааныг товлох, даргалах;

4.1.3. Үндэсний хорооны ажлын албаны даргыг томилж, чөлөөлөх;

4.1.4. Үндэсний хороог дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

4.1.5. Үндэсний хорооны үйл ажиллагааны тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулах.

4.2. Үндэсний хорооны гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.2.1. Үндэсний хорооны хуралдаанд асуудал оруулж, хэлэлцүүлэх;

4.2.2. Үндэсний хорооны шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хариуцсан салбар, чиглэлийн дагуу хяналт тавих;

4.2.3. хариуцсан салбар, чиглэлийн дагуу Үндэсний хороонд холбогдох мэдээ, тайлан, статистик тоо баримтыг гаргаж өгөх;

4.2.4. Үндэсний хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлантай танилцах, хорооноос хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах.

4.3. Үндэсний хорооны гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаарх саналаа урьдчилан бичгээр хүргүүлж болно.

**Тав. Үндэсний хорооны ажлын алба**

5.1. Үндэсний хороо нь ажлын алба (цаашид “Ажлын алба” гэх)-тай байх бөгөөд ажлын алба нь хорооны өдөр тутмын ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

## 5.2. Ажлын алба дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.2.1. Үндэсний хорооны жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах;

5.2.2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хууль тогтоомж, Үндэсний хорооны шийдвэрийг холбогдох албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

5.2.3. Үндэсний хорооны үйл ажиллагаанд шаардагдах тайлан, мэдээ, статистик тоо баримт, лавлагааг холбогдох байгууллагаас гаргуулах, бэлтгэх, мэдээллийн сан бүрдүүлэх;

5.2.4. Үндэсний хорооны хуралдааныг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах, хорооны шийдвэрийг хэлбэржүүлж гаргах;

5.2.5. Үндэсний хорооны үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.

5.3. Үндэсний хороо нь ажлын албаны даргатай байх бөгөөд ажлын албаны дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.3.1. Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж, хорооны даргаар батлуулах;

5.3.2. Үндэсний хорооны хуралдааны тэмдэглэл хөтлөх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.3.3. Ажлын албаны ажилтныг томилж, чөлөөлөх.

## **Зургаа. Бусад зүйл**

6.1. Үндэсний хороо нь дараахь эх үүсвэрээс санхүүжиж, үйл ажиллагаагаа эрхлэн явуулна:

6.1.1. улс, орон нутгийн төсөв;

6.1.2. гадаад улс, олон улсын байгууллагын хандив, зээл, тусламж;





6.1.3. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, хөрөнгө;

6.1.4. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

6.2. Үндэсний хороо нь тухайн жилийн үйл ажиллагааныхаа тайланг дараа жилийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 2

**Индекс: 200003**